



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/423

Булган сум

Газрын хэмжээ өөрчлөх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар баталсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Б.Амартүвшин (ГЮ95121117)-гийн Булган сум 6 дугаар баг Залуус 17 дугаар гудамж 1710 тоотод байршилтай 6308003826 нэгж талбар бүхий амины орон сууц зориулалтаар эзэмшиж буй 964 м<sup>2</sup> газрыг 1005 м<sup>2</sup> болгон илүү талбайн дуудлага худалдааны анхны үнийг төлүүлэн кадастрын зураглалын дагуу газрын хэмжээг өөрчилсүгэй.

2. Б.Амартүвшинтэй газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны А/149 дүгээр захирамжийн Б.Амартүвшинтэй холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6324010551